



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/406

Хэрлэн сум

Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Ус, цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 04 дүгээр, "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" 05 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой хээрийн түймрийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраахад дэмжлэг үзүүлэх, газар тариалан, бэлчээрийн ургамлын ургалтад шаардлагатай хөрсний чийг нэмэгдүүлэх, хуурайшилт, цөлжилтийг сааруулах зорилгоор аймгийн хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн үйл ажиллагааны зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Экспедицийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, шаардлагатай үед цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж тухай бүр тайлагнаж ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Б.Хэрлэнчимэг)-д үүрэг болгосугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



09
1/408

Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 09-ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Нийт дүн
1	Шатахуун	2,000,000
2	Томилолт	2,200,000
3	Урсгал засвар	800,000
Бүгд		5,000,000



60C/3

۰۰۰ ۰۰۰ ۰۰۰
۰۰۰ ۰۰۰ ۰۰۰

[illegible]

۳. خدمت‌نمایی و محرمی: در مسئولیت‌ها، در سووم‌محرم وین و هم‌سپشتن ..

[illegible]

۴.. مسکن دمع هو، منشعسحق رعمصررا دن سحسب مر حبس صحنزا در بحدب سحنسب و رعمصحن دن رعمصرره
دمعص بر مسرعهصره دن مسروق . صحق در سدا مر ربحر مر صحنزا (۱ . مفسوق) - ۵ . رعمصحن هو ربحر صروق
سحنسق دن سحسب مر حبس صحنزا در زامن مر صحنزا (۶ . صحنسحنسب) - هو صمر صمر سحنسبصحن ..

[illegible]